



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
О.БАЙГАЛЬСАЙХАН ТАНАА

2025.03.25 № 55
танай _____-ны № _____-т

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга тайлангуудад аудит хийхээр байсан.

Бидний үзэж байгаагаар Татгалзсан санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласны дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга тайлангуудад дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөлөл нь санхүүгийн тайланд өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Татгалзсан санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болох ба MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”: 6 төрийн аудитын зарчим, 6.4.3.1.3 Санал дүгнэлт, 6.4.3.1.3.3 Татгалзсан – Аудитор тодорхой бус байдал, хамрах хүрээний хязгаарлалтаас шалтгаалан хангалттай ба зохистой нотлох зүйл олж авах боломжгүй бөгөөд тэдгээр нь материаллаг болоод өргөн тархсан үед, Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/66 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Санхүүгийн аудитын зарчим” стандартын 64-т Аудитор нь дараах гурван төрлийн өөрчлөлттэй санал дүгнэлтийг гаргаж болно: ... татгалзсан санал дүгнэлт – тодорхойгүй байдал болон хамрах хүрээний хязгаарлалтаас шалтгаалж аудитор хангалтай, зохистой аудитын нотолгоог олж авах боломжгүй, энэ нь материаллаг бөгөөд өргөн тархсан үед гэсний дагуу дүгнэлт өгөхөөс татгалзсан болно. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангийн төсвийн захирагчид санхүүгийн тайлангийн аудит хийх тухай 2025.01.08-ны өдрийн 05, 2025.01.14-ны өдрийн 16 дугаартай албан бичиг хүргүүлсэн боловч хуулийн хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлээгүй.
2. 2025.03.21-ний өдрийн 75 дугаартай албан бичгээр ирүүлсэн санхүүгийн байдлын тайланд харилцах дансны үлдэгдэл 3,028.1 сая, авлага 7,398.1 сая, бараа үйлчилгээний зардлын өр төлбөр 1,168.7 сая, урьдчилж орсон

42250223+

орлого 2,518.9 сая тайлант үеийн алдааны залруулга 1,190.8 сая төгрөг, тайлант үеийн үр дүн (6,150.6) сая төгрөг гэж ирүүлсэн.

3. Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвийн санхүүжилт нь 442.9 сая төгрөгөөр зөрүүтэй, сангаас олгох тэтгэмжийг бүрэн олгосон гэх боловч санхүүгийн байдлын тайланд 1,168.7 сая төгрөгийн өр төлбөр тайлагнасан, мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 29,136.8 сая төгрөгөөр тайлагнасан боловч дансны хуулгаар 29,920.9 сая төгрөгийн зарлага гарсан бөгөөд 784.1 сая төгрөгийн зөрүүтэй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга дансанд 1,190.8 сая төгрөгийг бүртгэсэн боловч холбогдох тайлбар тодруулга, нотлох баримтыг ирүүлээгүй.
4. Дээрх тайлангуудад тайлагнасан санхүүжилт, өр төлбөр, зардал, алдааны залруулга, тайлант үеийн үр дүнд Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд горим сорил хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн **нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана**”, 20 дугаар зүйлийн 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/243 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 2.2. Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 2.2.в-т “... **Энэхүү боловсруулалтыг санхүүгийн программ хангамжийн тусламжтайгаар** мөнгөн хөрөнгийн данс бүрээр тодорхойлно” 2.2.г-т. “Тайлангийн хугацаанд мөнгөн хөрөнгийн данс бүр дээр гарсан ажил гүйлгээ нэг бүрийг анхан шатны баримттай тулган шалгаж, холбогдох данснуудад үнэн зөв бичигдсэн эсэхийг хянаж үзсэний эцэст мөнгөн хөрөнгийн дансдын тайланг гаргана ...” гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА